

Тайлангийн маягт, хавсралт мэдээ,  
нөхөх заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан”-гийн маягт /ТТ-07/-ыг 1 дүгээр, “Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн хавсралт мэдээ”-г 2 дугаар, “Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн маягыг нөхөх заавар”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хавсралтаар батлагдсан тайлангийн маягт, хавсралт мэдээний загварыг Татварын удирдлагын нэгдсэн системд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Татвар төлөгчид үйлчлэх газар /Д.Хүрэлчулуун/, Мэдээллийн технологийн төв /Х.Батбаяр/-д даалгасугай.

3. Батлагдсан маягтын дагуу тайланг хүлээн авч, татварын тооцоо хийхийг Том татвар төлөгчийн газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ



Татварын ерөнхий газрын даргын  
20... оны ... сарын ... -ны өдрийн  
... дугаар тушаалын ... хавсралт

# МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА Маягт ТТ-07

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫГ МОНГОЛ УЛСААС ХЭРЭГЖҮҮЛДЭГ ГАДААДЫН АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАН

ТТ-ийн дугаар:  Утас:   
ТТ-ийн нэр:  Факс:   
Тайлант он:

Тухайн тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй бол  энд тэмдэглэнэ үү.  
(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Мөр	Дүн
I	II	III
<b>А.Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулах албан татварын тооцоолол:</b>		
1. Нийт орлогын дүн (2+10)	1	
2. Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдох орлого (3+4)	2	
2.1.Хувьцаа, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл борлуулсны орлого	3	
2.2.Хуулийн 10.1.2, 10.1.3-т зааснаас бусад биет бус хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого	4	
3. Хасагдах зардлын дүн (6+7)	5	
3.1.Хувьцаа, үнэт цаасыг худалдаж авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэл	6	
3.2.Борлуулсан, шилжүүлсэн биет бус хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгийн үлдэгдэл өртөг	7	
4. Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого (2-5)	8	
5. Ногдуулсан албан татвар (8 * хуулийн 20.1, 20.2.7-д заасан хувиар)	9	
<b>Б.Тусгай хувь хэмжээгээр ногдуулах албан татварын тооцоолол:</b>		
6. Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлого (11+12+13+15+17)	10	
7. Эрхийн шимтгэлийн орлого	11	
8. Ногдол ашгийн орлого	12	
9. Хүүгийн орлого	13	
Ногдуулсан албан татвар ((11+12+13)*10 хувь)	14	
10. Гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл, нэгж эрх худалдан авсан албан татвар төлөгчийн хүүгийн орлого	15	
Ногдуулсан албан татвар (15*5 хувь)	16	
11. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого	17	
Ногдуулсан албан татвар (17*2 хувь)	18	
12. Тусгай хувь хэмжээгээр ногдуулсан албан татвар (14+16+18)	19	
<b>В. Албан татвар ногдуулах тооцоолол:</b>		
13. Хуулийн дагуу бусад суутгуулсан албан татвар	20	
14. Төлбөл зохих албан татвараас хасагдах гадаад улсад ногдуулан төлсөн албан татвар	21	
15. Нийт төлбөл зохих албан татвар (9+19-20-21)	22	

Тайланг үнэн зөв гаргасан:  Тайланг хүлээн авсан:   
Захирал /дарга/  Татварын улсын байцаагч:   
Ерөнхий нягтлан бодогч:   
Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч:

Татварын тайлан, хавсралт мэдээ  
Татварын удирдлагын нэгдсэн системээс  
үүсгээсэн кодоор баталгаажуулна.

Татварын ерөнхий газрын даргын  
20... оны .... сарын .... -ны өдрийн  
..... дугаар тушаалын .... хавсралт

**Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг  
гадаадын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын  
тайлангийн хавсралт мэдээ**

Нийтлэг хувь хэмжээгээр албан татвар ногдох орлогын мэдээ /ХМ-07(1)/

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Д/Д	Борлуулалтын орлогын төрөл	Монгол Улсад болон Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого	Гадаад улсад олсон орлого	Нийт орлого
1	2	3	4	5
	Нийт дүн			

Хасагдах зардлын мэдээ /ХМ-07(2)/

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Д/Д	Зардлын төрөл	Дүн	Хуулийн 13.1-д заасан нөхцөлийг	
			Хангасан	Хангаагүй
1	2	3	4	5
1	Хувьцаа, үнэт цаасыг худалдаж авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэл			
2	Борлуулсан, шилжүүлсэн биет бус хөрөнгө болон хөдлөх эд хөрөнгийн үлдэгдэл өртөг			
	Нийт дүн			

Хуулийн дагуу бусдад татвар суутгуулах орлогын мэдээ /ХМ-07(3)/

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Д/Д	Суутгагч аж ахуйн нэгжийн		Орлогын төрөл	Татвар ногдуулах орлого	ногдуулах албан татвар		Татвар суутгагдсан эсэх	Суутгуулсан татвар	Суутгуулаагүй татвар
	нэр	ТТД			хувь	дүн			
1	2	3	4	5	6	7	8	9	10
			Нийт дүн						

Татварын тайлан, хавсралт мэдээг  
Татварын удирдлагын нэгдсэн системээс  
үүсгэсэн кодоор баталгаажуулна.

Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл  
зохих албан татвараас хасаж тооцох мэдээ /ХМ-07(4)/

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

№	Гадаад улсын нэр	Татварын жилд гадаад улсад олсон орлого	Татвар ногдуулах орлого	ногдуулах албан татвар		Тайлант жилд гадаад улсад олсон орлогоос тухайн орны хуульд заасан хувь хэмжээгээр төлсөн татвар		Монгол Улсад хасах албан татвар
				Хувь	Дүн	Хувь	Дүн	
1	2	3	4	5	6 =( 4*5 )	7	8 =(4*7)	9 =(6 - 8)
	Нийт дүн							

Татварын тайлан, хэвсралт мэдээг  
Татварын удирдлагын нэгдсэн системээс  
үүсгээсэн кодоор баталгаажуулна.

## **Үйл ажиллагааны удирдлагыг Монгол Улсаас хэрэгжүүлдэг гадаадын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн маягтыг нөхөх заавар**

Энэхүү тайлангийн маягтаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 31 дүгээр зүйлийн 31.1-д заасан Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч болон Монгол Улсад байнга оршин суугч хувь хүн нь энэ хуулийн 31.8-д заасны дагуу дараагийн татварын жилийн 02 дугаар сарын 10-ны дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.

Тайланг гаргахдаа Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Татварын тайлан үйлдэх, тушаах, хүлээн авах, боловсруулах, тайланд залруулга хийх журам”-ыг баримтална. Тайлан нь 3 хэсгээс бүрдэх бөгөөд тайланг нөхөхдөө 3 дугаар баганад тухайн үзүүлэлтийн дүнг өссөн дүнгээр, төгрөгөөр бөглөнө.

### **Нэг.Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулах татварын тооцоолол:**

1. Нийт орлогын дүн буюу 1 дүгээр мөрийн дүн нь 2, 11 дүгээр мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.

2. Нийтлэг хувь хэмжээгээр албан татвар ногдох орлого буюу 2 дугаар мөрийн дүн нь 3, 4 дүгээр мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно. Энэ дүн нь *Нийтлэг хувь хэмжээгээр албан татвар ногдох орлогын мэдээ /ХМ-07(1)/-ний* 5 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.

3. Хасагдах зардлын дүн буюу 5 дугаар мөрийн дүн нь 6, 7 дугаар мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно. Энэ дүн нь *Хасагдах зардлын мэдээ /ХМ-07(2)/-ний* 3 дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.

4. Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого буюу 8 дугаар мөрийн дүн нь 2 дугаар мөрийн дүнгээс 5 дугаар мөрийн дүнг хассан дүнгээр тодорхойлогдоно.

5. Ногдуулсан албан татвар буюу 9 дүгээр мөрийн дүн нь 8 дугаар мөрийн дүнг хуулийн 20.1-д заасны дагуу 0-6 тэрбум төгрөг бол 10 хувиар, 6 тэрбум төгрөгөөс дээш албан татвар ногдуулах тухайн жилийн орлого олсон тохиолдолд 600 сая төгрөг дээр 6 тэрбум төгрөгөөс дээш давсан орлогод 25 хувиар нэмж, 20.2.7-д заасан 22.1.1, 22.1.2, 22.1.3-т зааснаас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа жилийн 300 сая төгрөг хүртэл албан татвар ногдох орлого олсон, албан татвар төлөгчийн тухайн албан татвар ногдуулах орлогод 1 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.

### **Хоёр. Тусгай хувь хэмжээгээр ногдуулах татварын тооцоолол:**

6. Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлого буюу 10 дугаар мөрийн дүн нь 11, 12, 13, 15, 17 дугаар мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.

7. Эрхийн шимтгэлийн орлого буюу 11 дүгээр мөрийн дүн нь хуулийн 9.1.2-т заасан орлогын дүн байна. Энэ дүн нь тухайн орлогын *Хуулийн дагуу бусдад татвар суутгуулсан орлогын мэдээ /ХМ-07(3)/-ний* 5 дугаар баганын нийт дүн, *Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцох мэдээ мэдээ /ХМ-07(4)/-ний* 4 дүгээр баганын нийт дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

8. Ногдол ашгийн орлого буюу 12 дугаар мөрийн дүн нь хуулийн 9.1.3-т заасан орлогын дүн байна. Энэ дүн нь тухайн орлогын *Хуулийн дагуу бусдад татвар суутгуулсан орлогын мэдээ /ХМ-07(3)/-ний* 5 дугаар баганын нийт дүн, *Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцох мэдээ мэдээ /ХМ-07(4)/-ний* 4 дүгээр баганын нийт дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

9. Хүүгийн орлого буюу 13 дугаар мөрийн дүн нь хуулийн 9.1.4-т заасан орлогын дүн байна. Энэ дүн нь тухайн орлогын *Хуулийн дагуу бусдад татвар суутгуулсан орлогын мэдээ /ХМ-07(3)/-ний* 5 дугаар баганын нийт дүн болон *Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл*

*зохих албан татвараас хасаж тооцох мэдээ мэдээ /ХМ-07(4)/-ний 4 дүгээр баганын нийт дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.*

10. Ногдуулсан албан татвар буюу 14 дүгээр мөрийн дүн нь 11, 12, 13 дугаар мөрүүдийн нийлбэр дүнг 10 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.

11. Гадаад, дотоодын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл, нэгж эрх худалдан авсан албан татвар төлөгчийн хүүгийн орлого буюу 15 дугаар мөрийн дүн нь хуулийн 9.1.4, 9.4-т заасан орлогын дүн байна. Энэ орлогын дүн нь тухайн орлогын *Хуулийн дагуу бусдад татвар суутгуулсан орлогын мэдээ /ХМ-07(3)/-ний 5 дугаар баганын нийт дүн болон Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцох мэдээ мэдээ /ХМ-07(4)/-ний 4 дүгээр баганын нийт дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.*

12. Ногдуулсан албан татвар буюу 16 дугаар мөрийн дүн нь 15 дугаар мөрийн дүнг 5 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.

13. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого буюу 17 дугаар мөрийн дүн нь хуулийн 10.1.1-д заасан орлогын дүн байна. Энэ дүн нь тухайн орлогын *Хуулийн дагуу бусдад татвар суутгуулсан орлогын мэдээ /ХМ-07(3)/-ний 5 дугаар баганын нийт дүн болон Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих албан татвараас хасаж тооцох мэдээ /ХМ-07(4)/-ний 4 дүгээр баганын нийт дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.*

14. Ногдуулсан албан татвар буюу 18 дугаар мөрийн дүн нь 17 дугаар мөрийн дүнг 2 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.

15. Тусгай хувь хэмжээгээр ногдуулсан албан татвар буюу 19 дүгээр мөрийн дүн нь 14, 16, 18 дугаар мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.

#### **Гурав. Албан татвар ногдуулах тооцоолол:**

16. Хуулийн дагуу бусдад суутгуулсан албан татвар буюу 20 дугаар мөрийн дүн нь бусдад суутгуулсан албан татварын дүн байна. Энэ дүн нь *Хуулийн дагуу бусдад татвар суутгуулсан орлогын мэдээ /ХМ-07(3)/-ний 9 дүгээр баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

17. Төлбөл зохих татвараас хасагдах гадаад улсад ногдуулан төлсөн албан татвар буюу 21 дүгээр мөрийн дүн нь хуулийн 23.1-д заасны дагуу хасаж тооцох албан татварын хэмжээг 23.3.1, 23.3.2-т заасан шалгуураар тооцсон дүнгийн аль багаар нь тооцсон дүн байна. Энэ дүн нь *Гадаад улсад ногдуулан төлсөн албан татварыг төлбөл зохих албан татвараас хасах тооцоолол мэдээ /ХМ-07(4)/-ний 9 дүгээр баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.*

18. Нийт төлбөл зохих татварын дүн буюу 22 дугаар мөрийн дүн нь 9, 19 дүгээр мөрүүдийн нийлбэр дүнгээс 20, 21 дүгээр мөрүүдийн дүнг хасаж тодорхойлно.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР